



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 35,236,667.00 (гучин таван сая хоёр зуун гучин зургаан мянга зургаан зуун жаран долоон) төгрөгийн балансын үнэ, 30,688,669.00 (гучин сая зургаан зуун наян найман мянга зургаан зуун жаран есөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Батцоож, Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (хуучин нэрээр) Д.Түмэнбаяр, Хөвсгөл аймгийн Хилийн цэргийн 0257 дугаар ангийн захирагч хурандаа Б.Баасансүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132004632
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 2 дүгээр сарын 16 өдрийн
89 дугаар тогтоолын хавсралт

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН (ХУУЧИН НЭРЭЭР)
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг /төгрөг/	Шилжүүлэн авах байгууллага
1	Суудлын автомашин УАЗ Фургон, улсын дугаар 47-41 ХӨВ	2011	27,280,000.00	27,280,000.00	0.00	Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст
2	Суудлын автомашин Ландкрузер-200, улсын дугаар 19-22 ХӨА	2013	7,956,667.00	3,408,669.00	4,547,998.00	Хөвсгөл аймгийн Хилийн цэргийн 0257 дугаар ангид
3	Нийт дүн		35,236,667.00	30,688,669.00		